



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

“Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх,
эрсдэлийг бууруулах-2028” арга хэмжээ
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх зорилго бүхий “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.УЛАМБАЯР



Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 05 дугаар сарын 21-ны
өдрийн 18 дугаар тогтоолын хавсралт

“ГАМШИГ, ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ-2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

Дэлхий дахинд олон улс орон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулах, гамшгийг тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зэрэг үүрэг амлалтыг авч, хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч жил бүр тохиолдох гамшгийн тоо хэмжээ буурахгүй, түүнээс учрах хохирлын хэмжээ мөн даган нэмэгдсээр байна.

Түүнээс гадна өмнө нь учирч байгаагүй шинэ төрлийн халдварт өвчин, цар тахал нүүрлэж гамшгийн тоо давтамж ихсэж байгаа нь цаашид ирж буй гамшиг аюулыг тооцож хохирол багатай даван туулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах, гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлэх хэрэгцээ гарч байна.

Дүүргийн хэмжээнд гарч байгаа гамшиг ослын шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, бууруулахад чиглэсэн хамтын үйл ажиллагааг зохион байгуулах, байгууллага, иргэд хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028” арга хэмжээний хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Гамшиг ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх замаар учрах хохирлыг бууруулах зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1.Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлж аврах ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийт, сайн дурын хэсгийн оролцоог хангах, чадавхжуулах.

3.Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төрийн байгууллага, олон нийтийн оролцоотой зохион байгуулж, гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.

4.Дүүргийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийн зураглал гарган эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

5.Гал түймрийн эрсдэлийг бууруулах, шалтгаан нөхцөлийг арилгах, арга хэмжээг зохион байгуулна.

Гурав.Арга хэмжээний зорилт, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1:Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлж аврах ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.

1.2.Онцгой байдлын ерөнхий газар болон дүүргийн гадаад улстай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд алба хаагчдыг туршлага судлах сургалтад хамруулна.

1.3.Гал унтраах, аврах 86 дугаар ангийг бүрэн ашиглалтад оруулж үйл ажиллагааг жигдрүүлэн аврах ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Шаардлагатай техник хэрэгслийг үе шаттайгаар нэмэгдүүлж, аврах ажиллагааны чанар хүртээмж нэмэгдэж, иргэдийн амь нас эд хөрөнгийг хурдан шуурхай авран хамгаалах чадавх нэмэгдэнэ.

Алба хаагчдыг гадаад улсад судлах сургалтад хамруулснаар мэргэжлийн ур чадвар дээшилнэ.

Гал түймэр унтраах аврах 86 дугаар анги ашиглалтад орж үйл ажиллагаа жигдэрснээр зуслангийн бүс, хил залгаа дүүргүүдийн иргэдийн аюулгүй байдал хангагдана.

Зорилт 2:Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”-ийн оролцоог хангах, чадавхжуулах.

2.1.Дүүргийн 1-24 дүгээр хороодын “Сайн дурын бүлгэм”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, гишүүдийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2.2.Дүүргийн “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”, Улаан загалмайн хороотой хамтран гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийг иргэд, олон нийтэд зохион байгуулна.

2.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан, амьжиргааны түвшин доогуур орлоготой иргэдэд тохирсон арга барилаар сургалт, арга хэмжээ аяныг зохион байгуулна.

Хүрэх үр дүн: Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, иргэд, олон нийтийн сайн дурын оролцоо 50%-д хүрч мэдлэг, ойлголт дээшилнэ.

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн аян, өдөрлөг, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад заавар, зөвлөмж өгөгдсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн гамшгийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдэж гамшиг ослоос өөрийгөө хамгаалах чадавхтай болсон байна.

Зорилт 3: Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төрийн байгууллага, олон нийтийн оролцоотой зохион байгуулж, гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.

3.1. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.2. Дүүргийн 1-24 дүгээр хороодод олон нийтийн оролцоотой эрсдэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулиудад хүүхэд төвтэй эрсдэлийн үнэлгээг зохион байгуулна.

3.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн сургалтыг дүүргийн хэмжээнд бүх шатанд зохион байгуулна.

3.4. Үер, ой хээр, шар өвс, гал түймэр, тарваган тахал зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас үүсэх гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах дадлага сургуулийг зохион байгуулах, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

Хүрэх үр дүн: Гамшгийн эрсдэлийн үнэлгээг олон нийтийн болон хүүхдийн оролцоотой зохион байгуулж эрсдэлийн бууруулах төлөвлөгөө гарсан байна.

Үер, ой хээрийн түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Иргэд, олон нийтийн оролцоотой дадлага сургуулийг зохион байгуулж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн бууруулах талаарх мэдлэг ойлголт нэмэгдэн хариу арга хэмжээ авах бэлэн байдлын чадавх дээшилнэ.

Зорилт 4: Дүүргийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.1. Дүүргийн газар хөдлөлт, ой хээрийн болон объектын гал түймэр, үер, шар ус, халиа дошин, хүн малын гоц халдварт өвчнөөр нарийвчилсан үнэлгээг хийж, зураглал боловсруулна.

4.2. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийнэ.

Хүрэх үр дүн:Дүүргийн хэмжээнд газар хөдлөлт, ой хээрийн болон объектын гал түймэр, үер, шар ус, халиа дошин, хүн малын гоц халдварт өвчний нарийвчилсан үнэлгээ хийгдэж эрсдэлийн зураглалыг гаргасан байна.

Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эрсдэлийн үнэлгээ хийгдэж, үнэлгээний тайлан баталгаажсан байна.

Зорилт 5:Гал түймрийн эрсдэлийг бууруулах, шалтгаан нөхцөлийг арилгах, арга хэмжээг зохион байгуулна.

5.1.Галын аюулаас урьдчилан сэргийлэх /ГАУС/ хяналт, шалгалтыг дүүргийн 1-24 дүгээр хороодтой хамтран зохион байгуулж зөрчлийг илрүүлнэ.

5.2.Гал түймрийн улсын хяналт, шалгалтыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагад зохион байгуулна.

Хүрэх үр дүн:Хороодод галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж ажиллана.

Гал түймрийн улсын хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд байцаагчийн мэдэгдэл, дүгнэлт өгч зөрчил арилгуулах арга хэмжээ зохион байгуулна.

Дөрөв.Хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

4.1.“Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028” арга хэмжээг 2024-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

4.2.1. Улс, нийслэл, орон нутгийн төсөв

4.2.2. Бусад эх үүсвэр

Тав.Хэрэгжүүлэгч байгууллага

5.1.Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газар
- Дүүргийн Онцгой байдлын хэлтэс
- Дүүргийн боловсролын хэлтэс
- Дүүргийн 1-24 хороод
- Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх дүгнэх ажлыг дүүргийн Онцгой байдлын хэлтэс удирдлага зохион байгуулалтаар ханган, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Зургаа.Хяналт, шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч талуудыг тэгш оролцоог хангаж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба үр дүнгийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

Арга хэмжээний хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны чиглэлийн үр дүнгээр үнэлнэ.

Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараах аргачлалаар дүгнэнэ:

- “Үр дүнтэй”- зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь /90%-100%/
- “Тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь /60%-89%/ хүртэл
- “Эрчимжүүлэх шаардлагатай”- зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31%-59%/
- “Үр дүн багатай” - зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 - /0%-30%/

Хяналт-шинжилгээ үнэлгээг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар хийнэ.

Шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
			2025 он	2026 он	2027 он	2028 он
Зорилт 1.Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлж аврах ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
Гамшигтай тэмцэх чадавхын бэлэн байдал	Хувь	90%	91%	91,5%	92%	92,5%
Техник, тоног төхөөрөмжийг багаж зэвсэглэмжийн нэмэгдүүлсэн тоо	Тоо	82 нэр төрлийн 1366 ш	1400	1500	1600	1700
Гадаад улсад алба хаагчдыг туршлага судлах сургалтад хамруулсан тоогоор	Тоо	1	3	3	4	5

Дүүргийн газар хөдлөлт, ой хээрийн болон объектын гал түймэр, үер, шар ус, халиа дошин, хүн малын гоц халдварт өвчний нарийвчилсан үнэлгээг хийлгүүлэх	Тоо	1	1	1	1	1
Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага аж ахуйн нэгжүүдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх	Тоо	38	40	45	50	55
Зорилт 5.Гал түймрийн эрсдэлийг бууруулах, шалтгаан нөхцөлийг арилгах, арга хэмжээг зохион байгуулах						
Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн зохион байгуулсан ажлын тоо	Тоо	21	25	30	35	40
Галын аюулаас урьдчилан сэргийлэх /ГАУС/ хяналт шалгалт зохион байгуулах	Тоо	8	9	10	11	12
Галын аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг, удирдамж, хөтөлбөрийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион явуулах	Тоо	7	7	7	7	7